



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/54

Хатан суудал

Нийтийн цэвэрлэгээ зохион байгуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.6 дахь заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.1, 9.4.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүх нийтийн цэвэрлэгээг 2022 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 14-17 цагийн хооронд аж ахуйн нэгж, албан байгууллага, дэлгүүр, шатахуун түгээх станц, айл өрхүүдийг тус тус хамруулан зохион байгуулсугай.

2. Тогтоосон хугацаанд аж ахуйн нэгж, дэлгүүр, шатахуун түгээх станцуудыг ажиллуулахгүй байхыг Хэсгийн төлөөлөгч (Г.Эрдэнэбилэг)-д үүрэг болгосугай.

3. Сумын айл өрхүүдэд чанга яригчаар зарлан мэдээллэх ажлыг Байгаль хамгаалагч (А.Гантулга), Хатансуудал 5 дугаар багийн Засаг дарга (Б.Амаржаргал) нарт хариуцуулсугай.


4. Нийтийн цэвэрлэгээний өдөр сумын төвд байгаа айл өрхүүдээ идэвхтэй хамруулахыг 1 дүгээр багийн Засаг дарга Д.Батаа, 2 дугаар багийн Засаг дарга Ц.Намхайхорол, 3 дугаар багийн Засаг дарга С.Ганхүлэг, 4 дүгээр багийн Засаг дарга С.Баттулга нарт үүрэг болгосугай.

5. Лагерь хорооллуудыг хариуцаж цэвэрлэгээнд идэвхтэй албан байгууллагуудын хуваарийг хавсралтаар баталсугай.

6. Цэвэрлэгээнд оролцсон болон оролцоогүй иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг гарын үсгээр баталгаажуулан бүртгэж, тайлан мэдээг Байгаль хамгаалагч (А.Гантулга)-д 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдөр хүлээлгэн өгөхийг хороолол хариуцсан албан байгууллагын дарга, эрхлэгч нарт даалгасугай.

7. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Ж.Энхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  О.МӨНХБАТ



642201029